БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/140/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Баянхонгор 2019 он


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат
Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Цэцэгмаа
Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn
Аудитор: П.Амаржаргал
Утас: 88106992 Цахим хаяг: amar_802002@yahoo.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| АДБОУС | Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт |
| АОУС | Аудитын олон улсын стандарт |

## Агуулга

1 Аудитын гэрчилгээ ..... 3
2 Аудитын тайлан ..... 3
2.1 Оршил ..... 3
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 3
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 4
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 6
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 6
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... 6
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 7
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 7
2.11 Шилэн дансны мэдээлэл ..... 7
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 7
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 8
3 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 10
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 10
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 11
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 12
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 14
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 15

# 1 Аудитын гэрчилгээ

# 2 Аудитын тайлан

## 2.1 Оршил

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянцагаан сумын Засаг даргын тамгын дарга М.Чинбат-т танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 20-ноос 2019 оны 02 дугаар сарын 20–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн

баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор П.Амаржаргал хариуцаж хэрэгжүүлэв.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 10 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянцагаан сумын ЗДТГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянцагаан сумын ЗДТГазар нь “Сум орон нутгаа хөгжүүлэх, нийт ард иргэдэд хууль сурталчилж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж ажиллах, дотоод ажлаа сайжруулах, төлөвлөгөө зорилтоо биелүүлэх, төсвөө үр ашигтай зарцуулахад оршино" гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянцагаан сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сум орон нутгаа хөгжүүлж ард иргэддээ хууль сурталчилж, дээд шатны байгууллагуудаас баталж гаргасан хууль тогтоол, заавар журам, дүрмийг баримталж байгууллагын үйл ажиллагааг өндөр түвшинд хангаж ажиллах чиг үүрэгтэй.

Баянцагаан сумын ЗДТГ-ын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй болно.

## 2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянцагаан сумын ЗДТГ-ын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 41 буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Баянцагаан сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп" ХХК-ийн "Acolous" санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Баянцагаан сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

## 2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Баянцагаан сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## 2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь улсын төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын хувьд байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 501,6 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 10,0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд алдаа, зөрчилтэйд залруулах асуудал гараагүй болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Сая төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 1 | 8.1 | |
| | Дүн | 1 | 8.1 | |

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг

Менежментийн захидлаар хүргүүлэв.

## 2.9 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Байхгүй

## 2.10 ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянцагаан сумын ЗДТГ-ын чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 378,2 сая төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 338,9 сая төгрөг буюу 89,3 хувьтай байгаа нь 2018 онд 378,2 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулан 39,3 сая төгрөг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

## 2.11 ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ

Баянцагаан сумын ЗДТГ-ын Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно. Шилэн дансны цахим мэдээллийн санд төсөв гүйцэтгэлтэй холбоотой мэдээллээс Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр) 1, 2-р саруудад хугацаа хоцорсон, Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (Тухай бүр) 1, 6-р сард хугацаа хоцорсон, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (Бүтэн жилээр,Бүтэн жилээр,Хагас жилээр,Улирал бүр,Сар бүр) 2-р сард хугацаа хоцорсон, Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авахтай холбоотой мэдээллийн Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 2-р сард хугацаа хоцорсон, Бусад төрлийн мэдээллийн Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр (Тухай бүр) 2-р сард, Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт (Тухай бүр) 2-р сард, Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн (Тухай бүр) 2-р сард мэдээллийг хугацаа хоцрон мэдээлсэн байна.

## 2.12 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 2.13 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянцагаан сумын ЗДТГ-ын 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

## 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Баянцагаан сумын ЗДТГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд орших буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Төсвийн зарцуулалт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Тайлант хугацааны цалингийн зардлаас бусад төсвийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг шалгахад Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2,1 дэх заалтыг зөрчиж Нөөц хөрөнгийн зардлаас уралдаан тэмцээн зохион байгуулах, засвар үйлчилгээ хийх, нутгийн зөвлөлийн уулзалтын зардал, цэрэг татлагын хоолны зардал, лектор урьж ажиллуулах зэрэг урсгал үйл ажиллагаанд 8,1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, төсвийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2,1 дэх заалт тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Батлагдсан төсвийг үр ашигтай зарцуулаагүй байх, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах нь төсөвт хүндрэл учруулах нөлөөтэй.

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулахдаа Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2,1 дэх заалтыг мөрдөж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 04 дугаар сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **24,041,344.00** | **26,816,344.00** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 24,041,344.00 | 26,816,344.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,782,944.00 | 24,063,544.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 94,500.00 | 708,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 00.00 | 66,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,688,444.00 | 23,289,044.00 |
| 35600 | Мал амьтад | 8,258,400.00 | 2,752,800.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,138,069,688.14** | **1,269,492,916.64** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,138,069,688.14 | 1,269,492,916.64 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,137,768,646.37 | 1,226,710,374.83 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,267,531,769.00 | 2,254,638,376.29 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -1,291,690,882.00 | -1,226,936,042.64 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 107,577,550.00 | 119,624,800.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -84,012,054.17 | -57,135,833.08 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 216,901,012.83 | 214,307,612.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -175,732,910.86 | -147,176,075.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 64,272,001.00 | 63,681,001.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,951,292.46 | -32,226,916.53 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 61,400,000.00 | 29,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -22,876,666.97 | -13,416,666.41 |
| 39217 | Ном | 22,350,120.00 | 22,350,120.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 301,041.77 | 42,782,541.81 |
| 39301 | Програм хангамж | 1,785,000.00 | 1,785,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,483,958.23 | -1,696,458.19 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 42,694,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,162,111,032.14** | **1,296,309,260.64** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,162,111,032.14** | **1,296,309,260.64** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,162,111,032.14 | 1,296,309,260.64 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 650,338,910.00 | 693,032,910.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 650,338,910.00 | 693,032,910.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 377,014,408.22 | 383,446,863.79 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 377,014,408.22 | 377,014,408.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 6,432,455.57 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 134,757,713.92 | 219,829,486.85 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,162,111,032.14** | **1,296,309,260.64** |

## 4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **434,878,676.00** | **508,073,429.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **15,320,690.00** | **43,946,230.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 15,320,690.00 | 43,946,230.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 15,320,690.00 | 43,946,230.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 968,790.00 | 1,020,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 14,351,900.00 | 42,926,230.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **419,557,986.00** | **464,127,199.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 45,955,216.00 | 83,744,590.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,955,216.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 83,744,590.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 289,736,000.00 | 378,231,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 289,736,000.00 | 378,231,000.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 81,582,086.00 | 00.00 |
| 133003 | Хөрөнгийн | 81,582,086.00 | 00.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,284,684.00 | 2,151,609.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,284,684.00 | 2,151,609.00 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,112,021,137.16** | **461,193,156.34** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,112,021,137.16** | **461,193,156.34** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,071,558,521.16 | 364,765,112.34 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 175,268,764.00 | 173,176,902.00 |
| 210101 | Үндсэн цалин | 159,741,919.00 | 173,176,902.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,526,845.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,255,326.00 | 20,671,602.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,255,326.00 | 13,942,147.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 1,753,370.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 1,387,335.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 326,250.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 3,262,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 17,562,928.00 | 16,075,821.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,412,188.00 | 1,773,221.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,150,740.00 | 14,302,600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 31,750,130.00 | 36,619,980.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,727,420.00 | 3,943,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 19,166,560.00 | 26,080,990.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,401,800.00 | 114,990.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 15,000.00 | 9,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 325,800.00 | 234,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,393,050.00 | 6,236,600.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 2,720,500.00 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 410,905.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 410,905.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 13,514,690.00 | 4,530,650.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,400,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,114,690.00 | 4,530,650.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,728,500.00 | 6,202,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,728,500.00 | 6,202,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 40,096,386.00 | 12,398,060.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 40,096,386.00 | 10,324,860.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 1,936,200.00 |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 00.00 | 137,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 768,381,797.16 | 94,679,192.34 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,421,500.00 | 19,332,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 524,500.00 | 312,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 753,435,797.16 | 75,034,492.34 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 40,462,616.00 | 96,428,044.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 10,000,000.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 00.00 | 10,000,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 30,930,084.00 | 22,474,709.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 2,284,684.00 | 2,151,609.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,403,800.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 4,491,600.00 | 20,323,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,750,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,268,742.00 | 63,953,335.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,268,742.00 | 40,344,245.00 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 23,609,090.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,263,790.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,263,790.00 | 00.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-677,142,461.16** | **46,880,272.66** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 40,447,817.09 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 33,289,785.38 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 7,158,031.71 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -40,447,817.09 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-677,142,461.16** | **6,432,455.57** |

## 4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **338,944,690.00** | **465,147,199.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **968,790.00** | **1,020,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 968,790.00 | 1,020,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 968,790.00 | 1,020,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 968,790.00 | 1,020,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **337,975,900.00** | **464,127,199.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 45,955,216.00 | 83,744,590.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 45,955,216.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 83,744,590.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 289,736,000.00 | 378,231,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 289,736,000.00 | 378,231,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 2,284,684.00 | 2,151,609.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 2,284,684.00 | 2,151,609.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **338,944,690.00** | **465,147,199.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **338,944,690.00** | **465,147,199.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **298,382,074.00** | **335,732,885.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 175,267,968.00 | 173,176,931.00 |
| 210101 | Үндсэн цалин | 159,741,123.00 | 163,288,044.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,526,845.00 | 9,888,887.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,256,122.00 | 20,671,573.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,256,122.00 | 16,692,003.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 785,766.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 455,621.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 00.00 | 118,152.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 00.00 | 2,620,031.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,600,148.00 | 16,262,971.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,727,408.00 | 1,773,221.00 |
| 210302 | Түлш, халаалт | 13,872,740.00 | 14,489,750.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,642,570.00 | 22,267,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,311,350.00 | 2,892,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,778,100.00 | 19,114,610.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,483,620.00 | 150,660.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 69,500.00 | 109,830.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 385,800.00 | 106,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 385,800.00 | 106,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 7,552,190.00 | 5,499,150.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,552,190.00 | 5,499,150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 5,728,500.00 | 6,202,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 5,728,500.00 | 6,202,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 42,213,926.00 | 63,971,460.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 42,213,926.00 | 61,866,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 2,105,060.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 10,734,850.00 | 27,575,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,210,350.00 | 26,975,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 524,500.00 | 600,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **40,562,616.00** | **129,414,314.00** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 42,986,270.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 00.00 | 42,986,270.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 31,030,084.00 | 22,474,709.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 2,284,684.00 | 2,151,609.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 18,403,800.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 4,691,600.00 | 20,323,100.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 5,650,000.00 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 4,268,742.00 | 63,953,335.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,268,742.00 | 40,344,245.00 |
| 213404 | Хөрөнгийн | 00.00 | 23,609,090.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 5,263,790.00 | 00.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 5,263,790.00 | 00.00 |

## 4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 650,338,910.00 | 134,757,713.92 | 1,253,141,855.22 | 00.00 | 2,038,238,479.14 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **650,338,910.00** | **134,757,713.92** | **1,253,141,855.22** | **00.00** | 2,038,238,479.14 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -152,757,871.63 | 00.00 | -152,757,871.63 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **650,338,910.00** | **134,757,713.92** | **377,014,408.22** | **00.00** | 1,162,111,032.14 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **650,338,910.00** | **134,757,713.92** | **377,014,408.22** | **00.00** | 1,162,111,032.14 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **650,338,910.00** | **134,757,713.92** | **377,014,408.22** | **00.00** | 1,162,111,032.14 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 85,071,772.93 | 00.00 | 00.00 | 85,071,772.93 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 42,694,000.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 42,694,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 6,432,455.57 | 00.00 | 6,432,455.57 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-** | **693,032,910.00** | **219,829,486.85** | **383,446,863.79** | **00.00** | 1,296,309,260.64 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | **нээрх үлдэгдэл** | | | | | |

## 4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 307,672,000.00 | 287,410,793.00 | 378,231,000.00 | 338,906,755.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 307,672,000.00 | 287,410,793.00 | 378,231,000.00 | 338,906,755.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 289,211,600.00 | 269,180,393.00 | 284,971,100.00 | 275,597,385.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 187,234,500.00 | 186,628,780.00 | 178,639,400.00 | 173,176,931.00 |
| 210101 | Үндсэн цалин | 171,573,500.00 | 171,552,190.00 | 169,039,400.00 | 163,288,044.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 15,661,000.00 | 15,076,590.00 | 9,600,000.00 | 9,888,887.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,715,100.00 | 20,540,767.00 | 21,436,700.00 | 20,671,573.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,765,332.00 | 10,775,766.00 | 15,144,300.00 | 16,692,003.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,030,103.00 | 4,989,645.00 | 1,410,700.00 | 785,766.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,537,649.00 | 1,492,356.00 | 1,128,600.00 | 455,621.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 307,316.00 | 298,399.00 | 282,100.00 | 118,152.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,074,700.00 | 2,984,601.00 | 3,471,000.00 | 2,620,031.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 19,027,700.00 | 14,583,966.00 | 18,136,000.00 | 16,262,971.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,561,700.00 | 2,312,300.00 | 3,045,300.00 | 1,773,221.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,466,000.00 | 12,271,666.00 | 14,790,700.00 | 14,489,750.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 00.00 | 300,000.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,755,000.00 | 16,813,840.00 | 22,409,500.00 | 22,267,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,000,000.00 | 1,606,140.00 | 3,095,400.00 | 2,892,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,900,000.00 | 13,504,960.00 | 18,894,300.00 | 19,114,610.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,355,000.00 | 1,523,940.00 | 319,800.00 | 150,660.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 500,000.00 | 178,800.00 | 100,000.00 | 109,830.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 1,000,600.00 | 375,000.00 | 106,600.00 | 106,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,600.00 | 375,000.00 | 106,600.00 | 106,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 21,736,700.00 | 19,794,000.00 | 5,766,000.00 | 5,499,150.00 |
| 210602 | Тавилга | 21,736,700.00 | 19,794,000.00 | 00.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 00.00 | 5,766,000.00 | 5,499,150.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,600,000.00 | 4,484,000.00 | 6,425,700.00 | 6,202,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,600,000.00 | 4,484,000.00 | 6,425,700.00 | 6,202,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 4,987,000.00 | 2,120,840.00 | 4,052,200.00 | 3,835,960.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад | 4,987,000.00 | 2,120,840.00 | 1,448,200.00 | 1,730,900.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 00.00 | 2,604,000.00 | 2,105,060.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 6155000.00 | 3839200.00 | 27999000.00 | 27575300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,155,000.00 | 3,839,200.00 | 27,399,000.00 | 26,975,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 00.00 | 00.00 | 600,000.00 | 600,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 18460400.00 | 18230400.00 | 93259900.00 | 63309370.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 | 72,936,800.00 | 42,986,270.00 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 00.00 | 00.00 | 72,936,800.00 | 42,986,270.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 18,460,400.00 | 18,230,400.00 | 20,323,100.00 | 20,323,100.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 18,460,400.00 | 18,230,400.00 | 00.00 | 00.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 00.00 | 20,323,100.00 | 20,323,100.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 00.00 | 00.00 | 378,231,000.00 | 338,906,755.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 377,631,000.00 | 337,886,755.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 00.00 | 00.00 | 377,631,000.00 | 337,886,755.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 00.00 | 00.00 | 600,000.00 | 1,020,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 00.00 | 600,000.00 | 1,020,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 23.00 | 23.00 | 23.00 | 23.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 07.00 | 07.00 | 07.00 | 07.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 07.00 | 07.00 | 07.00 | 07.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 09.00 | 09.00 | 09.00 | 09.00 |